

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦӨМИЙН ФИЗИКИЙН СУДАЛГААНЫ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БОЛОРТУЯА ТАНАА

2021.02.25 № 07/555
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 2,814.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, тодруулга, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,983,944.84	53,174,972.85
33	АВЛАГА	-	191,028.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	191,028.01
34	УРЬДЧИЛГАА	50,846,362.00	50,846,362.00
34600	Урьдчилж гарсан зардал	50,846,362.00	50,846,362.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,137,582.84	2,137,582.84
35100	Түүхий эд материал	209,000.00	209,000.00
35110	Тусгай зориулалттай материал	209,000.00	209,000.00
35400	Хангамжийн материал	1,928,582.84	1,928,582.84
35470	Бусад хангамжийн материал	1,928,582.84	1,928,582.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	152,297,079.86	165,739,586.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	152,297,079.86	165,739,586.73
39200	Биет хөрөнгө	150,984,208.76	165,307,734.45
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	407,946,732.42	257,221,929.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(262,769,983.15)	(96,838,902.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,711,800.00	8,711,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,964,340.51)	(4,847,092.31)
39217	Ном	1,060,000.00	1,060,000.00
39300	Биет бус хөрөнгө	1,312,871.10	431,852.28
39301	Програм хангамж	1,727,408.76	1,727,408.76
39302	Хуримтлагдсан элэгдэл	(863,704.32)	(1,295,556.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	539,000.00	539,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(89,833.34)	(539,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	205,281,024.70	218,914,559.58
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	191,028.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	191,028.01
41300	Өглөг	-	191,028.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	191,028.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	205,281,024.70	218,723,531.57
51	Засгийн газрын хувь оролцоо	205,281,024.70	218,723,531.57
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	177,196,868.00	177,196,868.00
51200	Хуримтлагдсан үр дүн	28,084,156.70	(805,787.83)
51210	Өмнөх үеийн үр дүн	(66,935,504.22)	28,084,156.70
51220	Тайлант үеийн үр дүн	95,019,660.92	(28,889,944.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	42,332,451.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	205,281,024.70	218,914,559.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	376,475,949.28	362,169,502.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,342,849.28	18,605,002.58
120	Нийтлэг татварын бус орлого	66,342,849.28	18,605,002.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,342,849.28	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	66,342,849.28	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	18,605,002.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,133,100.00	343,564,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	310,133,100.00	343,564,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	310,133,100.00	343,564,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	281,456,288.36	391,059,447.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	281,456,288.36	391,059,447.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,890,175.47	383,485,036.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,335,444.05	286,557,073.00
210101	Үндсэн цалин	215,335,444.05	222,185,250.82
210102	Нэмэгдэл	-	40,209,822.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	24,162,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,237,215.88	34,903,215.00
210201	Тэтгэврийн даатгал	21,264,076.88	25,214,151.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,177,505.00	2,966,372.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	926,644.00	2,292,456.00
210204	Ажилгүйдлийн даатгал	169,908.00	355,441.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,699,082.00	4,074,795.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,625,306.66	13,460,038.13
210301	Гэрэл, цахилгаан	9,728,091.30	11,542,152.40
210302	Түлш, халаалт	2,897,215.36	1,917,885.73
2104	Хангамж, бараа материалын зардал	876,500.00	703,763.70
210401	Бичиг хэрэг	391,500.00	282,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	182,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,000.00	239,763.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	430,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,638.56	366,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,638.56	201,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,410,070.32	47,494,947.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	21,410,070.32	47,494,947.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,566,112.89	7,574,410.17
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,566,112.89	7,574,410.17
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	7,574,410.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,566,112.89	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	95,019,660.92	(28,889,944.53)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	95,019,660.92	(28,889,944.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	310,133,100.00	343,564,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,133,100.00	343,564,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	310,133,100.00	343,564,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	310,133,100.00	343,564,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	288,327,682.00	343,564,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,327,682.00	343,564,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	282,761,569.11	335,990,089.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	215,335,444.05	286,557,073.00
210101	Үндсэн цалин	194,530,762.00	222,185,250.82
210102	Нэмэгдэл	13,257,300.00	40,209,822.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,547,382.05	24,162,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,237,215.88	34,903,215.00
210201	Тэтгэврийн даатгал	19,685,317.61	25,214,151.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,161,300.00	2,966,372.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	929,600.00	2,292,456.00
210204	Ажилгүйдлийн даатгал	232,400.00	355,441.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,228,598.27	4,074,795.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,625,306.66	13,460,038.13
210301	Гэрэл, цахилгаан	9,728,091.30	11,542,152.40
210302	Түлш, халаалт	2,897,215.36	1,917,885.73
2104	Хангамж, бараа материалын зардал	876,500.00	703,763.70
210401	Бичиг хэрэг	391,500.00	282,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	182,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,000.00	239,763.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	430,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,687,102.52	366,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,687,102.52	201,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	165,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,566,112.89	7,574,410.17
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,566,112.89	7,574,410.17
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	7,574,410.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,566,112.89	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	21,805,418.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	21,805,418.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,805,418.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	21,805,418.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,805,418.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(21,805,418.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	177,196,868.00	-	(66,935,504.22)	110,261,363.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	177,196,868.00	-	(66,935,504.22)	110,261,363.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	95,019,660.92	95,019,660.92
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	177,196,868.00	-	28,084,156.70	205,281,024.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	42,332,451.40	-	42,332,451.40
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(28,889,944.53)	(28,889,944.53)
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	177,196,868.00	42,332,451.40	(805,787.83)	218,723,531.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,608,200.00	286,557,073.00	51,127.00	99.9
210101	Үндсэн цалин	216,254,500.00	222,185,250.82	(5,930,750.82)	102.7
210102	Нэмэгдэл	61,572,100.00	40,209,822.18	21,362,277.82	65.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,781,600.00	24,162,000.00	(15,380,400.00)	275.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,692,200.00	34,903,215.00	3,788,985.00	90.2
210201	Тэтгэврийн даатгал	27,227,800.00	25,214,151.00	2,013,649.00	92.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,866,100.00	2,966,372.00	(100,272.00)	103.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,292,800.00	2,292,456.00	344.00	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	573,300.00	355,441.00	217,859.00	62.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,732,200.00	4,074,795.00	1,657,405.00	71.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,189,300.00	13,460,038.13	3,729,261.87	78.3
210301	Гэрэл, цахилгаан	9,083,700.00	11,542,152.40	(2,458,452.40)	127.0
210302	Түлш, халаалт	8,105,600.00	1,917,885.73	6,187,714.27	23.6
2104	Хангамж, бараа материалын зардал	708,800.00	703,763.70	5,036.30	99.2
210401	Бичиг хэрэг	282,000.00	282,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	182,000.00	182,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	244,800.00	239,763.70	5,036.30	97.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	366,000.00	366,000.00	-	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,000.00	201,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	165,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	343,564,500.00	335,990,089.83	7,574,410.17	97.8
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болортуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт бүртгэл тайлагналд хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал С.Тунгалаг хянан удирдаж, ахлах аудитор Г.Ариунбат, аудитын менежер Б.Батцэцэг аудиторын туслах Т.Оюун, Г.Ариунболд нар хариуцаж хэрэгжүүлэв.

Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цөмийн физикийн судалгааны төвийн эрхэм зорилго нь:

Цөмийн физик, технологи, инженерчлэлийн чиглэлээр шинэ мэдээлэл, үр дүн гарган авах, шинэ арга зүй, технологи боловсруулах; багаж төхөөрөмж зохион бүтээх судалгаа хийж, сургалт явуулдаг үндэсний тэргүүлэх байгууллага байхад оршино.

Цөмийн физикийн судалгааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- **Суурь судалгаа:** Цөмийн бүтэц, урвалын механизм, нейтроны болон реакторын физикийн туршлагын ба онолын судалгаа;
- **Цөмийн эрчим хүч, цөмийн түлшний судалгаа:** Уран олборлолт, боловсруулалтын технологи, цөмийн түлшний цикл, судалгааны болон эрчим хүчний реакторын судалгаа; цөмийн эрчим хүч ашиглах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах;
- **Цөмийн болон цацрагийн технологийн судалгаа:** Трансмутац, цацраг идэвхт изотоп, цөмийн аналитик арга зүй, цацрагийн технологийн судалгаа, боловсруулалт, инноваци (эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, геологи, уул уурхай, үйлдвэр зэрэгт нэвтрүүлэх);
- **Сургалт:** Цөмийн физик, технологи, инженерчлэлийн бүх шатны боловсрол олгох; мэргэшүүлэх; дадлагажуулах; мөн цөмийн технологи, эрчим хүчийг ашиглахын ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах, мэдлэг дээшлүүлэх сургалт явуулах;
- Захиалгат төсөл хэрэгжүүлэх замаар цацрагийн хамгаалалт, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын судалгаа хийж, зөвлөмж гаргах; цацраг идэвхт ашигт

малтмал болон цөмийн эрчим хүч ашиглах салбарын стандарт, норм, дүрэм, журам, заавар, зөвлөмж боловсруулах зэрэг судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа эрхэлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”.(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална”. (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.)
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 472 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт ” Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ” (2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөх).

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Цөмийн физикийн судалгааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 281,456.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,814.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,633.5 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	191.0	191.0
Урьдчилгаа	50,846.4	50,846.4	-
Бараа материал	2,137.5	2,137.5	-
Үндсэн хөрөнгө	152,297.1	165,739.6	13,442.5
Нийт хөрөнгийн дүн	205,281.0	218,914.5	13,633.5
Нийт өр төлбөр	-	191.0	191.0
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	205,281.0	218,723.5	13,442.5
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	205,281.0	218,914.5	13,633.5

Авлага дансны үлдэгдэл 191.0 мянган төгрөг болж өссөн нь санхүүгийн тайлангийн аудитаар хувь хүний орлогын албан татвартай холбоотой залруулга хийгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 165,739.6 мянган төгрөг болж 13,442.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 191.0 мянган төгрөг болж өссөн санхүүгийн тайлангийн аудитаар хувь хүний орлогын албан татвартай холбоотой залруулга хийгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 218,723.5 мянган төгрөг болж 13,442.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 343,564.5 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 343,564.5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 335,990.1 мянган төгрөгийг зарцуулж 7,574.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 335,990.1 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 51.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх зардлыг 3,789.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,729.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 5.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 153 мэдээллийг хугацаандаа оруулж, 17 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 21 гүйлгээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланг аудитын түүвэр шалгалтад хамруулсан ба өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага байхгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 131,263.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36,958.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,147.1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 85,157.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл нь өмнөх оны Э балансын дүнгээс 28,084.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг санхүүгийн тайланд залруулав.;
2. Хувь хүний орлогын албан татварын тайланг цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 19 ажилтанд нийт 8,874.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгө олгосныг шууд бус орлогоор тайлагнасныг хувь хүний орлогын албан татварын тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 94,304.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9,147.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Цалин хөлсний давтан тооцоолол үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа 6 ажилтанд нийт 191.0 мянган төгрөгийн хөнгөлөлт тооцож бодсон байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:", санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал батламж мэдэгдлийг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Төслийн санхүүжилтээс цалинжуулах 7 ажилтанд 7,251.4 мянган төгрөгийн цалин, 680.2 мянган төгрөгийн цолны нэмэгдэл, 196.1 мянган төгрөгийн профессорын нэмэгдэл, 828.5 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл нийт 8,956.1 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг байгууллагын батлагдсан төсөвт зардлаас олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах "заалт, заалт УСНББОУС 3-ын 27-д Санхүүгийн тайланд байгууллагын

санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 170 мэдээлэл байршуулахаас нийт 17 мэдээллийг хугацаа хожимдуулж, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 21 гүйлгээний мэдээллийг 12 дугаар сард байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 85,157.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараа санхүүгийн тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй.

Дараагийн аудитаар төсөл хөтөлбөрөөр бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Урьдчилж гарсан зардлын данстай холбоотой асуудал

1. Илрүүлэлт:

Хэрэгжиж дуусаагүй 4 төслийн нийт 50,846.4 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэхдээ төсөл тус бүрд дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна.

1.1. Эрсдэл:

Төслийн хэрэгжилтэд бүртгэлээр тавих хяналт суларч, өмч хөрөнгийг үрэгдүүлэх

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасныг мөрдөж ажиллах.

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2.Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Худалдан авалтын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын цахим системд бүртгэсэн дүн нь төлбөрийн баримтын дүнгээс 10,149.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

2.2. Эрсдэл:

Найдваргүй авлага, өр төлбөр, зарга маргаан үүсэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэж заасныг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цөмийн физикийн судалгааны төвийн хөдөлмөрийн дотоод журамд заагдаагүй 24,162.0 мянган төгрөгийн унаа хоолны нөхөн олговрыг захирлын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 тоот тушаалаар, өдрийн 6.0 мянган төгрөгөөр тооцон нийт ажилтнуудад олгосон байна.

3.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Хамтын гэрээнд энэ хуулиар шууд зохицуулагдаагүй дараах харилцааг зохицуулна", 18.1.1-д "үндсэн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх, түүний хэлбэр, олгох хугацаа, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олговрын хэмжээ, хөдөлмөрийн норм, нормативыг тогтоох, өөрчлөх, Ажилтанд олгох хоол, унааны зардал болон бусад нөхөх олговрын хэмжээг тогтоох" гэж хамтын гэрээг үндэслэн байгууллагын дотоод журамд нөхөн олговрын дүнг тогтоон, мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цөмийн физикийн судалгааны төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/255/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Цөмийн физикийн судалгааны төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал
	1	2	3	4	5
1	Цалин хөлсний давтан тооцоолол хийхэд үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлж байгаа 6 ажилтанд нийт 191.0 мянган төгрөгийн хөнгөлөлт тооцож бодсон байна.	191.0	Төлбөрийн акт тогтоох	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр
2	Цалин хөлсний давтан тооцоолол хийхэд төслийн санхүүжилтээс цалинжуулах 7 ажилтанд 7,251.3 мянган төгрөгийн цалин, 680.2 мянган төгрөгийн цолны нэмэгдэл, 196.1 мянган төгрөгийн профессорын нэмэгдэл, 828.6 мянган төгрөгийн зэргийн нэмэгдэл нийт 8,956.1 мянган төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг байгууллагын батлагдсан төсвөөс санхүүжүүлсэн байна.	8,956.1	Төлбөрийн акт тогтоох	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр
3	Хэрэгжиж дуусаагүй 4 төслийн нийт 50,846.4 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн зардлаар бүртгэхдээ төсөл тус бүрд дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй байна.	50,846.4	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр
4	Төлбөрийн баримтыг цахим системд бүртгэсэн дүн бэлтгэн нийлүүлэгч байгууллагын бүртгэсэн төлбөрийн баримтын дүнгээс 16 байгууллагын нийт 10,149.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	10,149.3	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр
5	Цөмийн физикийн судалгааны төвийн хөдөлмөрийн дотоод журамд заагдаагүй 24,162.0 мянган төгрөгийн унаа хоолны нөхөн олговрыг нийт ажилтнуудад захирлын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 тоот тушаалаар олгосон.	24,162.0	Зөвлөмж өгөх	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр

6	<p>Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 170 мэдээлэл байршуулахаас нийт 17 мэдээллийг хугацаа хожимдуулж, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 1 дүгээр сараас 11 дүгээр сарын нийт 368,519.1 мянган төгрөгийн орлого зарлагын 21 гүйлгээний мэдээллийг 12 дугаар сард нөхөж байршуулсан байна.</p>	-	Албан шаардлага	Захирлын үүрэг гүйцэтгэгч Нягтлан бодогч	Д.Болортуяа Д.Цасчихэр
	Нийт дүн	94,304.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 41/АД160058

Улаанбаатар хот

САГ-2021/255/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн ажлаас гадуур ажилласан төслийн 7 ажилтанд 7,251,263.00 (долоон сая хоёр зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран гурав) төгрөгийн цалин, 680,157.00 (зургаан зуун наян мянга нэг зуун тавин долоо) төгрөгийн цолны нэмэгдэл, 196,086.00 (нэг зуун ерэн зургаан мянга наян зургаа) төгрөгийн профессорын нэмэгдэл, 828,547.00 (найман зуун хорин найман мянга таван зуун дөчин долоо) төгрөгийн зэргийн нэмэгдэл, нийт 8,956,053.00 (Найман сая есөн зуун тавин зургаан мянга тавин гурван) төгрөгийг батлагдсан төсвөөс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цөмийн физикийн судалгааны төвөөс төслийн ажилтнуудад илүү олгосон 8,956,053.00 (Найман сая есөн зуун тавин зургаан мянга тавин гурван) төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Д.Цасчихэр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ИМ - ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

(Handwritten signature and stamp)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 40/A0160058

Улаанбаатар хот

САГ-2021/255/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлдэг, 6 ажилтанд нийт 191,028.01 (Нэг зуун ерэн нэгэн мянга хорин найман төгрөг нэг мөнгө) төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцсон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үндсэн ажлаас гадуур давхар ажил эрхэлдэг, 6 ажилтанд илүү тооцсон 191,028.01 (Нэг зуун ерэн нэгэн мянга хорин найман төгрөг нэг мөнгө) төгрөгийн татварын хөнгөлөлтийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Д.Цасчихэр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ИХМОНГОЛ
ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 154/AM60058

Улаанбаатар хот

CAГ-2021/88/CTA-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цөмийн физикийн судалгааны төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 170 мэдээллээс хугацаа хоцроосон 17 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Д.Цасчихэр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ИХМОНГОЛ
ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Г.АРИУНБАТ

